

«Монголын Нууц Товчоон»-ы түүхэн метафорын утга

Дүгэржавын БАДАМДОРЖ

Хэлбичгийн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор

Хураангуй: Зохиогч эл эрдэм шинжилгээний өгүүлэлдээ: “Монголын Нууц Товчоон”-ы метафорыг нарийвчлан ажиглаж, 780 гаруй жилийн тэртээ монголчууд хийсвэрлэн сэтгэж, метафор сэтгэлгээ хөгжиж байсныг тодолжээ. Ялангуяа, амьтан, загас, шувууны аяг аранисныг танин мэдээд, монгол хүний зарим зан чанарыг зүйрлэн илэрхийлсэн түүхэн метафор элбэг байгааг онцлон дурджээ. Тухайлбал: “Монголын Нууц Товчоон”-ы 78 дугаар зүйлд: Тэмүжин Хасар хоёр гэрт ирж ороход, ...Өэлүн үжин: “... Noqay metü, qablan metü, arslan metü, mangyus metü, singqor metü, ğuraqa metü, buura metü, ğino metü, anggir metü, ğöeböri metü, bars metü, bariq metü.” (МНТ, 1985:30) гэх зэргээр хуучин үгс үндэслэж, өтгөс үгс эшилж, машид зэмлэсэн ажээ.

Мөн зохиогч түүхэн метафорыг илэрхийлж буй, утга шилжүүлсэн бурхан, алтан, нохой гэх зэрэг үглэвэр, метафорын илтгэгч мэт, төдий, бол- гэх мэт үглэврийн утга учрыг тайлбарласан бөгөөд тус өгүүлэлдээ зохиогч “Монголын Нууц Товчоон”-ы домог зүйн болон онгон шүтээний зарим нэрсийг хүн, амьтны нэртэй харьцуулж үзээд, Бөртэ Чоно, Гоо Марал, Чингис, Ухаагч үнээ, Улаан бух, Цэгээн шар хүн, Шар нохой мэт, Тэв Тэнгэр гэх мэт оноосон нэрс, нийлэмж үгс бол түүхэн метафор утгатай гэж үзжээ. “МНТ”-ы метафорыг 1. Хэлний метафор, 2. Уран зохиолын метафор гэж хоёр ангилжээ.

Түлхүүр үг: Монголын нууц товчоон, утга зүй, түүхэн метафорын утга


Keyword: The Secret History of the Mongols, semantics, historical metaphor meaning

1.0 Удиртгал

“Монголын Нууц Товчоон”-ы эхний арван дэвтэр Чингис (1162-1227) хааныг өөд болсны хойтон шар хулгана жил (1228) зохиогдсон гэдэгт олонх судлагчид санал нийлж байна. Мөн сүүлчийн хоёр дэвтрийг Өгөдэй (1186-1241) хааныг нас барсны дараа нэмж бичсэн гэж үзвээс “Нууц товчоон”-ы

* © Д.Бадамдорж 2024
Email: d.badamdorj@mnun.edu.mn

XI-XII бүлгийн зохиогдсон цаг хугацаа нь 1241 оны үест холбогдоно.” (МНТ. 2000:09) гэж академич Д. Цэрэнсодном бичсэн байна. 1989 онд Парис хотноо чуулсан ЮНЕСКО-гийн Гүйцэтгэх Зөвлөлийн чуулганаас гаргасан тогтоолд: “Монголын Нууц Товчоон нь уран сайхан, гоо зүй, яруу найраг, хэлний шинжээрээ Монголын утга зохиолын түүхэн дэх хосгүй нандин бүтээл ..” (Пүрэвжав Э, 2023:11) хэмээн тэмдэглэжээ. Хэл шинжээчид юм үзэгдлийн аль нэг шинжийг товойлгон тодруулах зорилгоор түүнтэй төстэй өөр юм үзэгдлийн нэрээр утга шилжүүлэн, зүйрлэн нэрлэх найруулгын ур маяг нь метафор гэж ч үзсээр иржээ. “... Зүйр цэцэн үг, өвөрмөц хэллэг, төлөөлөл, тойруулал, эерүүлэл, егөөдөл, ёгтлол, хэтрүүлэл, ихэсгэл, багасгал гэх мэт уран дүрслэлийн хэрэглүүрүүдийн цаад үндэс нь бүгд зүйрлэлээс эх сурвалжтай байдаг.” (МУЗНТ, 2022:463) хэмээн үзсээр ч байна. Өөрөөр хэлбэл, чухамдаа метафор бол ястан үндэстэн нар хоёр зүйл юм, үзэгдлийн аль алины нь ноцтой шинжийг танин мэдэж, хосоор сэтгэсний үр дүнд бүтнэ. Орчин үед хэл шинжлэлийн танин мэдэхүйн утга зүйд метафорыг цөм судлагдахуун гэх болов. Метафор (“... Аль нэг юм үзэгдлийн адил төстэй талыг баримтлан утга шилжүүлэн хэрэглэхийг зүйрлэл гэдэг. Зүйрлэл нь нэлээд өргөн утгатай юм. Төмөрцэрэн Ж, 2023:25) бол хүмүүний тархины хийсвэрлэн сэтгэсэн уран үйл хөдөлгөөн учраас үглэврээр илэрхийлэх утгыг үглэврээр илэрхийлэх утгатай жишин харьцуулж холбож байгаа, дээд зэргийн хийсвэрлэлийн илрэл юм. Жишээ нь: ДАЛАЙ ХААН (“МНТ”-ы §280) хэмээх “Монголын Нууц Товчоон”-ы түүхэн өвөрмөц метафорын бүдүүвчийг сонирхоно уу. Үглэврийн утга гэдэг бол юм, ухагдахуун, хэлний тэмдэг гурвын шүтэлцээ учраас хүний их тархины бор гадаргад л утга боловсорч, тэнд хадгалагдаж байдаг агаад хэлний ямар нэгэн нэгжээр хүмүүст хүрч, санал бодлоо солилцдог ажээ. Метафор бол зүйрлэгдэхүүн, зүйрлэхүүн гэх хоёр бүрэлдүүлбэртэй байна. Учир зүйн хувьд эхлээд зүйрлэгдэхүүнийг, удаад нь зүйрлэхүүнийг танин мэдэж метафор бүтээдэг ажээ.



гэх хэлбэр утгын бүтэцтэй байна. Бүдүүвч № 1. Метафорын утга

Ш.Гаадамба: “Зүйрлэх нь адил төстэй хоёр үзэгдэл, ахуй амьдралд байдаг дээрээс ургаж гардаг болохоос биш, ямар ч хамаагүй зүйлийг шиг, мэт, адил, өөрцгүй, юу нь өөр вэ, чинээ, аятай, ...чилэн гэх зэрэг зүйрлэл бүтээх үгээр холбоод хийчихдэг зүйл биш байх. Юуг зүйрлэх, юутай зүйрлэх гэдэг хоёр

зүйлээс зүйрлэл бүтэх бөгөөд тэгэхдээ энэ хоёр зүйл ямар ямар талаараа адил төстэй байгааг нарийн ажсан байвал зохино. ... “Монголын Нууц Товчоон”-ы 78 дугаар зүйлд Тэмүжиний харгис догшин авиртайг Өэлүн эх зэмлэн хэлсэн үгэнд:

“Хавиргаа хазах

Хар **нохой** мэт

Хаданд довтлох

Харцага шонхор мэт.” гэсэн нь дүү Бэхтэрээ харваж алсан Тэмүжиний байдалд тохирсон зүйрлэл болно.” (1989:125-126) гэжээ. Чой. Лувсанжав: “... Хонь чоно хоёр шиг, төөрсөн төлөг шиг зэрэг нь тогтвортой хам хэллэг буюу зүйрлэсэн өвөрмиц хэллэг (metaphorical idioms) мөн. Иймээс зүйрлэсэн өвөрмиц хэллэг нь хэлний үгсийн сангийн нэгж болдог. ...” (2006:24) гэж үзжээ. Бид дээр дурдсан судалгааны ийм ийм саналыг үндэслэсэн болно.

- 1.1.Судалгааны зорилго: XIII зуун буюу дундад үеийн монгол хэлний утгазүйн зарим үзэгдлийг нарийвчлан шинжлэх, ялангуяа, “Монголын Нууц Товчоон”-ы хэлийг утга зүйн үүднээс судлах, монголчуудын түүхэн метафор бүтээсэн сэтгэхүй, сэтгэлгээг тодруулах.
- 1.2.Судалгааны хэрэглэгдэхүүн: Монголын Нууц Товчоо, судалгааны ном зохиол, толь бичиг,
- 1.3.Судалгааны арга: Хэл шинжлэлийн товчоолох, түүхэн харьцуулах гэх зэрэг аргаар судалсан.
- 1.4.Судалгааны ач холбогдол: Монгол хэлний түүхэн утга судлалын судалгааг ирээдүйд явуулахад одооноос зарим нэгэн судлагдахууныг нарийвчлан судалж, суурь тавих ач тустай болно.
- 1.5.Судалсан байдал: “Монголын Нууц Товчоон”-ы метафорыг Бүрэнбат (2002), Н.Мэнд (2005), Г.Цэвэлсүрэн (2006), Ж.Лувсандорж (2008), Д.Отгонтуяа (2008), Б.Нямжав (2008), С.Мөнхсайхан (2023) нарын зэрэг эрдэмтэд, залуу судлаачид сонирхон судалсан байна. Профессор Ж.Лувсандорж: “МНТ бол түүхийн дурсгал болохоор хуучин үг ихтэй, уран зохиолын дурсгал болохоор уран үг ихтэй юм. Уран үгсийн оньс нь метафор хэлц юм. Тэрний түлхүүр нь этносын сэтгэлгээний аргыг эзэмших явдал болно. Энэ тийм амар юм биш нь мэдээж.” (2008:52) гэсэн байна.

2. Судалгааны хэсэг

Монгол хэлний үгийн сан судлал, үгийн сангийн утга зүйн судалгааг гүнзгийрүүлэн явуулсан, эрдэмтэн Ж.Төмөрцэрэн: “... Хэлний зүйрлэл бол толь бичигт тэмдэглэгдэх бөгөөд уран зохиолын зүйрлэл бол толь бичигт орохгүй.” (2023:26) гэж метафорыг хоёр ангилсан ёсоор бид “Монголын Нууц Товчоон”-ы түүхэн метафорыг хоёр ангилан авч үзлээ. Хүний хэлний метафор бол уудам орон зайд, урт цаг хугацаанд үүсэн бүрэлдэж, хэрэглээ зүй, найруулга зүйн

үндсэн судлагдахуун ч юм.

Нэг. Хэлний түүхэн метафорын утга

Тэнгэр, байгаль, нийгмийн ямарваа юм, үзэгдлийн онцгой нэгэн шинжийг тодруулах зорилгоор нөгөө юм, үзэгдлийн адил төстэй шинжээр утгыг жишин харьцуулж, нүүдлийн соёл иргэншлийн унаган хэв шинж, жишиг хэмжүүрт суурилан түшиглэсэн, хураангуй бүрэлдүүлбэртэй, цөөн зүйрлэхүүнт дүрслэх ур маягийг хэлний метафор гэдэг.

“Монголын Нууц Товчоон”-ы хэл буюу 13 дугаар зууны /дундад үеийн/ монгол хэлний дүрслэх ур маяг түүхэн метафорыг нарийвчлан судлууштай судлагдахуун юм. Иймийн тул “Монголын Нууц Товчоон”-ы тэнгэр, бурхан, сав шим ертөнцтэй холбогдол бүхий нэг хэсэг түүхэн нийлэмж ба нийлмэл үглэвэр нь метафор утга илэрхийлдгийг нотолж, утга зүйн тайлбар хийлээ. Энэ нь монгол үндэстний эртний сэтгэлгээний унаган хэв шинж, эерэг утга юм. Үүнд:

Бурхан халдун: “МНТ”-ы §1. “... Onan müren-ü teriün-e Burqan qaldun-a nuntuyaju ...” (МНТ, 1985:10) гэсэн өгүүлбэр дэх газар нутгийн оноосон Бурхан халдун гэх нийлмэл нэрнээ “Дархан хүн, Бурхан ухаантай” гэх өдгөөгийн зүйр үгтэй холбон үзэж болох [Халдун (Tsagaan öndör -White Heights. Urgunge Onon, 2001:38) (зүйрлэгдэхүүн)] бурхан (зүйрлэхүүн) гэсэн газар нутгийн оноосон нэрнээ буй түүхэн метафор гэж үзэж болох юм. “МНТ”-ы §103. “Burqan qaldun-i manayar büri maliyasuyay Üdür büri öcisügey. Uruy-un uruy minu uqatuyay keen ... (МНТ, 1985:43) §179. ... Gurban müred-ün teriün ken-e ber bü bauludqun keejü ilebe.” (МНТ, 1985:114) гэж уг гарал үүслээрээ “бурхан” гэх үг, “халдун” гэх үг хоёр холбоогүй боловч, Бурхан халдун хайрхныг шүтэж ирсэн учраас бурхан мэт хад уул гэж нэрлэжээ. Бурхан - зүйрлэхүүн, Халдун - зүйрлэгдэхүүн юм.

Нөхөр шорлогодоо: Монгол хэлний “Зовох цагт нөхрийн чанар танигдана” гэсэн хэлцийн үүдэл нь болох “МНТ”-ны §13. “Dobun mergen ügülerün. Nökör ši-rolyada kejüü. ...” (МНТ, 1985:12) гэсний “nökör širolыada” хэмээхүй нь метафорт өвөрмөц хэлц бололтой. Ш.Гаадамба: “... Энэ холбоо үгийг бид «нөхрийн чанар шорлогодоо (ямар мах шорлон авч өгөхдөө) мэдэгдэх» гэсэн утгатай зүйр үг гэж тайлбарласан билээ” (1990:229) гэжээ. Бодвол, “шор долоолгохгүй (идэх юм огт өгөхгүй) гэсэн өвөрмөц хэлцтэй ч утга холбоо сүлбээтэй мэт. Үүнийг нарийвчилбал, [Нөхрийн чанар (зүйрлэгдэхүүн) - нөхөр шорлогодоо (зүйрлэхүүн)] гэсэн түүхэн метафор юм.

Бөртэ чоно, Гоо марал: “МНТ”-ы §1. “Činggis qayan-u hujaur deere teng-geri-eče jayaatu töregcen Börte čino ajuu. Gergei inü Qoay maral ajiay.” (МНТ, 1985:10) гэсний хүншүүлсэн Börte čino, Qoay maral гэх хоёр нийлмэл үг судлаачид, хэл шинжээчдийн анхаарлыг татсаар иржээ. Ш.Гаадамба: “Энэ бол бидний бодлоор угтаа жинхэнэ түүхэн хүн бус, харин монголчуудын гарал үүслийн домог-үлгэрийн онгон амьтны нэр байж магадгүй. Гэвч нөгөө талаар тэр гарал үүслийн онгон шүтээний нэрээр нэршсэн түүхт хүн байсан байж болохыг бас үгүйсгэх аргагүй.” (1990:222) гэсэн байхад, Д.Цэрэнсодном: “Сүүлийн

үед олонх судлагчид Бөртэ-Чино, Хоо Марал хоёрыг бодот хүний нэр бус, эрт балар цагийн домог-үлгэр, онгон шүтээний эрхэм нэр гэдэгт санал нэгтэй болж байна.” (2000:191) гэжээ. “Монголчууд Хөх чоно (Бөртэ чоно), Гоо марал, боржигид овгийнхон Цагаан шонхор шувуу, буриадууд Хун шувуу тотемтэй” (Чүлтэмсүрэн Р, 2021:240) гэдэг. Тотем нь хувьсал хөгжлийн явцад утга агуулга нь өөрчлөгдөж метафор болдог байна. Бид “Бөртэ Чино, Гоо Марал” хэмээх хоёр эрхэм нийлмэл нэрийг монголчуудын дээд үеийг эрхэмлэн, зүйрлэн нэрийдсэн түүхэн метафор гэж үзлээ. Өөрөөр хэлбэл, анхандаа, онгон шүтээний нэр байж байгаад, хүний сэтгэхүйн түүхэн хувьслын явцад эртний түүхэн хүмүүсийг онгон шүтээний нэрээр зүйрлэн нэрлэсэн ажээ. [Өтгөс дээдэс (зүйрлэгдэхүүн)-Бөртэ чоно, гоо Марал (зүйрлэхүүн)] бүхий түүхэн метафор юм.

Мөнх тэнгэр: Б.Сумьяабаатар: “Мөнх тэнгэр” гэдэг хэллэгийг анх хэрэглэсэн хүн бол Тэмүжин байна. Тэрбээр Чингис хаанд өргөмжлөгдөхөөсөө урьд буюу 1206 оны барс жилээс өмнө хэлжээ. Үүнийг, 1202 оны нохой жилээс хойш, 1204 оны хулгана жилээс урагш гэж тогтоож байна. Хээр газар хэлсэн.” (2008:XIX) хэмээн тодорхойлжээ. “МНТ”-ы §172. “*Činggis qaγan ügüleriin. Möngke tenggeri medetügey keejü ebceü-ben mökeeledbe ...*” (МНТ, 1985:104) гэсэн баримт байна. Монгол бөө мөргөлийн тэнгэр-шүтээн гэх ойлголт ёсоор [дээд тэнгэр - Мөнх тэнгэр] хэмээх зүйрлэгдэхүүн, зүйрлэхүүн бүхий түүхэн метафор юм.

Далай: “МНТ”-ы §280. “... *dalay-yin qaγan-u šülen-e hon-dur sürüg-ün nigen šilegü irge yaγaasu yaun buy.*” (МНТ. 1985:214) гэсний “dalay” хэмээх тодотгол үг бол өдгөөгийн “Далай лам” гэх цол нэртэй жишвэл, “аугаа их хаан, эзэн хаан, дээд” гэх зэрэг утга агуулгатай ажээ. [Хаан - Далай] гэх зүйрлэгдэхүүн, зүйрлэхүүн бүхий хэлний түүхэн метафор юм.

Чингис: “Чингис” хэмээх үгийн талаар монголч эрдэмтэд олон янзын санал гаргасан байдаг. Ц.Дамдинсүрэн: “Олонх эрдэмтэн Чингисийг тэнгис буюу тингис гэдэг үгнээс гарсан гэдэг. Энэ бол монгол, турк хэлний тэнгис далай гэсэн үг болно. Нууц товчоонд (§280) байна. Иймийн тул Чингис хаан гэдэг нь далай хаан гэсэн санаа байж болно. ... Юу боловч Чингис гэдэг цол бол Монголын Гүр хаан, Далай хаан, Даян хаан гэдэгтэй ойр утгатай үг юм.” (1957:72) гэж үзсэн байна. Буянбат: “Чингис гэдэг нь бөөгийн шашны шүтдэг Хажир Чингис тэнгэр гэдэг шүтээн байжээ.” (1985:126) гэсэн нь өргөмж нэр гэдгийг нотолж байгаа хэрэг юм. “Чингис” (“МНТ, §123. *Temüjin-i Činggis qaγan keen nereyide-jü qan bolγaba.*” (МНТ. 1985:59) хэмээх цол нэр бол далай мэт хэмээн утгалж болох бөгөөд Тэмүжинг Хажир Чингис тэнгэртэй зүйрлэн өргөмжилж нэрлэсэн утга бүхий метафор юм. Тодруулбал, [Тэмүжин-Чингис] гэх нь зүйрлэгдэхүүн, зүйрлэхүүн бүхий хэлний түүхэн метафор юм.

Ухаагч үнээ, ухаа үхэр, улаан бух: “МНТ”-ы §121. “*Qoaγčin ünien irejü ... Muqular qoa hūker yeke ger lüge deere ergüjü, ...*” (МНТ. 1985:57), §240. “... *hulaan buqa-yin yabuγsan mör-iyer ... mör bolγaju aula deere yaγuasū ...*” (МНТ. 1985:174)

гэх мэтээр “Qoayčin ünien, qoa hümer, hulaan buqa” гэсэн үхрийн зүсмээр метафор утга илэрхийлсэн байна. Энэ нь эрт цагт үхэр шүтэж байснаас улбаалж үүссэн бололтой. [Тэнгэрийн элч -ухаагч үнээ, ухаа үхэр, улаан бух] гэх зүйрлэгдэхүүн, зүйрлэхүүн бүхий түүхэн метафор юм. Эл гурван зүсмийн үхэр бол ид шидээр хүмүүнд тусалж буй нь сонин юм.

Цэгээн шар хүн: “МНТ”-ны §21. “Sönid büri çeügen šira küün ger-ün erüke dotoya-yin gegeer oroju keeli minu bilijü gegeen inu keeli-dür minu šinggekü bülee.” (МНТ, 1985:14) О. Лхагва: “Нууц товчоонд өгүүлснээр шөнө бүр сэмхэн ирдэг цэгээн шар хүн бол Дува сохорын өнөөх шар хөвүүн мөн.” (2021:158) хэмээн бичжээ. Энд “ЦЭГЭЭН ШАР” гэх нь дээд тэнгэрээс заяат төрсөн, цагаан ястай хүн хэмээсэн утга учиртай ажээ. Одоо үеийн “тэгээнтэн” гэсэн өргөмж нэртэй ойролцоо утгатай болов уу даа. [Дээд тэнгэрээс заяат төрсөн /хүн/-цэгээн шар /хүн/] гэх зүйрлэгдэхүүн, зүйрлэхүүн бүхий, чимэн тодотгосон түүхэн метафор юм.

Шар нохой мэт: “МНТ”-ы §21. “Garurun naran sara-yin kili-yer šira noqay metü šičabaljaju yarqu bülee.” (МНТ, 1985:14) Д. Цэрэнсодном: “Энэ хэллэгт Алунгоо эх нарны гэгээ гэрэлтэй адилтган өгүүлсэн “тэнгэр язгуурт хүнээ” шар нохойтой зүйрлэсэн нь сонирхолтой байна.” (2008:60) гэжээ. [Цэгээн шар хүн-шар нохой мэт] гэх зүйрлэгдэхүүн, зүйрлэхүүн бүхий түүхэн метафор юм.

Нялх Сэнгүм: “МНТ”-ы §165. “Tere üge-dür Činggis qayan dotoraan Wang qan Nilqa Senggüm qoyar-tur dura qočorjuu.” (МНТ, 1985:96) гэсний “нялх” гэсэн нь хоч нэрээр илэрсэн метафор бөгөөд, [Сэнгүм-Нялх] гэсэн зүйрлэгдэхүүн, зүйрлэхүүн бүхий түүхэн метафор юм.

Эм Таян: “МНТ”-ы §194. “... eme Tayang jirüke yadaran ene üges ügülejüü.” (МНТ, 1985:130) Ж. Лувсандорж: “... күрдүн-ү туул-ун белčigel-dür ese күргүсен em-e tayang (буквально. “баба Таян не достигший до пастбище телят в изгороди или дойных коров”) Доромжилсон метафор утга: эрх танхи, мэдлэг туршлагагүй (изнеженный, избалованный)” (2008:45-46) гэж утгалсан байна. Мөн хоч, доромж нэрээр тодотгосон, [Таян-Эм] гэсэн зүйрлэгдэхүүн, зүйрлэхүүн бүхий түүхэн метафор юм.

Хуст, Нарст, Саглагар мод: “Эртний монголчууд ой мод, бут, бургас, захын ганц мод, хори буриадууд хус модыг, ойрад, чорос овгийнхон уд/ур/ мод, хиад боржигид бургас зэрэг ургамлыг онго шүтээн болгож байжээ.” (Чүлтэмсүрэн. Р, 2021:240) “МНТ”-ы §133. “Ulja-yin Qusutu šitüen, Naratu šitüen-e Tatar-un Megüjin teriüten tatar tende qorya barijuu.” (МНТ, 1985:67), §206. “Basa Muqali-da Činggis qayan ügülerün. Bida Qorqonay jubur -un Qutula qan-u de/b/sekü saylar modun-a bauasu Muqali-da tenggeri-yin jaarin jaaysan üge temdeg-ün tula ...” (МНТ, 1985:151) гэснээс үзвэл, тэнгэрийн зайран заасан үг, тэмдэгтэй учраас [Шүтээн-Хуст, Нарст, Саглагар мод] гэсэн зүйрлэгдэхүүн, зүйрлэхүүн бүхий модны уламжлалт шүтлэгийн түүхэн метафор гэж болохоор байна.

Тэв тэнгэр: “Монголын Нууц Товчоо”-ы §244. “Qongqotaday Münglig ečige-

yin köüd doloan bülee. Doloan-u dumdatu Kököö, Teb tenggeri bülee.” (МНТ. 1985:176) Д. Цэрэнсодном: “Энэ нь монгол бичгийн хэлний төб /гол, төв/ гэдэгтэй холбогдолтой “Төв тэнгэр” буюу “Дээд тэнгэр” гэсэн утгатай байж болох юм.” (2000:337) гэжээ. Хөхөчү бөөгийн өргөмж нэр бол Тэв тэнгэр учраас [Хөхөчү бөө-Тэв тэнгэр] гэсэн зүйрлэгдэхүүн, зүйрлэхүүн бүхий өргөмжилсөн хүндэтгэл түүхэн метафор юм.

Зэв: “МНТ”-ы §147. “Jiryoaday neretü ajuu. Mön jebelekü aman çayan qula-yi minu aman niruu qarbuysan-u tula Jebe nereyidejü jebeleye imayi keen Jebe nereyidejü dergede minu yabu keen jarliy bolba.” (МНТ, 1985:81) гэж ихэд мэргэн харвасан Зургаадай гэдэг хүнийг “Зэв” гэж нэрлэсэн тул [Зургаадай (зүйрлэгдэхүүн) - Зэв (зүйрлэхүүн)] гэсэн түүхэн метафор ажээ. Эдгээр 14 үглэвэр, нийлмэл үг, нийлэмж үгийг утга зүйн талаас нь нарийвчилж байцаагаад, түүхэн метафор утгатай гэсэн санал дэвшүүлж байна.

Мөнхүү хэлний метафор бол нийлэмж үг, нийлмэл үг, нийлцийн хүрээнд үүсэн бүрэлдсэн, цөөн зүйрлэхүүнтэй байдаг. “Монголын Нууц Товчоон”-ы хэлийг ажиглахад, монгол хүн сэтгэн бодож хэлсэн, мэт, төдий гэх мэт илтгэгч бүхий хэлний зүйрлэл цөөнгүй бий. Жишээлбэл:

- “МНТ”-ы §31. Ödün hüsün inü ...çasun metü (өд үс нь ... цас мэт),
 §41. Köün inü mene metü (хүү нь мэлхий мэт),
 §59. şia-yin tedüy nödün (шагайн төдий нөж),
 §80. qosiliy-un tedüy çayan gürü (хошлогийн төдий цагаан чулуу),
 §82. üdür metü saraura (өдөр мэт саруул),
 §96. Eçige-lüge metü anda (эцэг лүгээ мэт анд),
 §111. Qoryosun-u tedüy amin-ıyan (хорголын төдий амиа),
 §147. Halayan-u tedüy yajar (алгын төдий газар),
 §149. Ürie daayan suryaqu metü suryan (үрээ даага сургах мэт

сурган),

§255. Boyda qatun bidan-u naran metü gegegen, naur metü delger sedkiltü bülee keebe. (Богд хатан бидний наран мэт гэгээн, нуур мэт дэлгэр сэтгэлт билээ хэмээв.)

§272. Ayta metü so (о) ngquju, irge metü bilijü (агт мэт сонгож, ирэг мэт ялгаж),

§276. ...aulas metü balayad ... (уулс мэт балгад)

§275. “... Saqaltan emeged saçaun bolju, ösügey-yer türjü, ölmi-ıyer geçikileküy keejüü.” (Сахалт эмгэд сацуутан болжээ. Өсгийгөөрөө түлхэж, өлмийгөөрөө гишгэлэх сэн хэмээж...) [Бат хаан (зүйрлэгдэхүүн) - сахалт эмгэд (зүйрлэхүүн) бүхий метафор юм.

§117. “... ebertü ünügün çayaan-i Temüjin-e unuulba.” (эвэрт үнэгэн цагааныг Тэмүжинд унуулав.) Цагаан /морь/ (зүйрлэгдэхүүн) - (үнэгэн зүйрлэхүүн) гэх мэт. [Жишээг Т. Дашцэдэн галигласан “МНТ” (1985) -оос эшлэв.]

Эртний болон дунд үеийн монгол хэлний энэ мэт түүхэн явган зүйрлэл бол “мэт, төдий” гэх мэт зүйрлэхүүний илтгэгчтэй байдаг билээ. Зүйрлэл бол маш

өргөн утга агуулгыг хамрах, хүний сэтгэхүйн үйл хөдөлгөөний үр дүн учраас хэл шинжлэлийн утга судлал гэх салбарт ямагт танин мэдэхүйн талаас нь судалж байдаг ажээ. Жишээлэхэд, “МНТ”-ы §117. Үнэгэн цагаан гэх морийг нэрлэсэн метафор бол үнэгний ч морины ч зүсмийг сайтар танин мэдсэний дараагаар хэлсэн байна. Ийнхүү үглэврийн юм ба урагдахуунд шүтэн барилдуулж, тухайн үглэврийн нэгэн ноцтой шинж буюу ноёлох утганцарт түшиглэж, метафор үүсдэг монгол хүний хэл, сэтгэхүйн холбоо байдаг ажээ. Монгол хэлний “алтан” хэмээх үгийн утгыг шилжүүлж, “үнэт, эрхэм” гэсэн үнэлэмж, шинж заасан утганцраар түүхэн метафорын зүйрлэхүүн болгосон байдаг. Энэ бол монгол хэлний түүхэн метафорын нэгэн эерэг шинж, утга юм. Үүнд:

Алтан босго: “МНТ”-ы §137. “... Činggis qayan-dur auljaju ügülerün: Altan bosoya sakiju atuyaу keen ögbe.” (МНТ. 1985:70) гэж Их монгол улсын үеийн өндөр үүдийг ийнхүү нэрлэж байсан бөгөөд [алтан (зүйрлэхүүн) - босго (зүйрлэгдэхүүн)] гэх хүндэтгэсэн, хэлний түүхэн метафор хэрэглэжээ.


Алтан жолоо: “МНТ”-ы §256. “... öere maqa küün-dür joriju бүкүй-dür je teli möngke tenggeri-de iheegdeesü altan jilua batuda tataju ireesü tende maqa boltuуai teli keejü.” (МНТ, 1985:192-193) §275. “... orusud irgen-i da/у/uliju harban nigen harin irgen-i жүг-tür oroуulju altan jilua ісүн tataju ...” (МНТ. 1985:206) гэжээ. Энэхүү “алтан жолоо татаж ...” гэх нийлц бол аян дайнд яваа хүмүүс зорин яваа зүг чигээ өөрчлөхийг хэлж байна. [Алтан (зүйрлэхүүн) - жолоо (зүйрлэгдэхүүн)] хэмээх түүхэн метафор ажээ.

Алтан аргамж: С. Мөнхсайхан: “...Монгол хэлний тогтвортой хэллэгүүд нь ихэвчлэн адилтгах, зүйрлэх аргаар бүтсэн байдаг онцлогтой. “Монголын нууц товчоо”-нд цөөнгүй өвөрмөц хэлц байдаг. ... 256 дугаар зүйлд гарах “Алтан аргамжаа тасалдаж (altan агуамji-іуан tasuldaju) хэмээх хэлцийн тухай авч үзье. Энэ нь “улс аймгуудтай тогтоосон найрамдалт харилцаа тасрах” гэсэн утгатай бөгөөд нүүдэлчдийн ойлголтоор аргамжаа нь эдэлгээний морь малыг хол явуулж идүүлэхгүй, тогтоон барьж байхад хэрэглэх урт дээс, уяаг хэлэх тул ... “алтан аргамжаа тасалдах” буюу найрсаг харилцааг тогтоон барьж байсан зүйлгүй болсныг илэрхийлнэ.” (2023:111) Ц. Түмэндэмбэрэл: “Урт сур аргамжаар адуу малыг аргамжих мэт харь орныг илгээсэн элчээрээ тогтоон барина гэсэн үзэл номлолын дагуу төрийн элч, гадаад бодлого, харилцаагаа “алтан аргамж” хэмээн нэрлэсэн ...” (2006:86) гэсэн нь алтан аргамж хэмээх өвөрмөц хэлц нь түүхэн метафор болохыг ч магадлан хэлжээ. Эл метафор бол олон улсын найрамдалт харилцааг л алтан аргамж гэж зүйрлэн хэлж ирсэн утгатай байна.

Алтан тэрэм: “МНТ”-ы §185. “Wang qan gened bui. Altan terem bosqaju qurimlamuy.” (МНТ. 1985:119) Ван ханы алтан тэрэм гэдэг бол дайн тулаанд ороход барих шар цацар байсан болов уу. Харин алтан гэх үгээр тэрэм/хана/-ийг тодотгож буй нь түүхэн метафор юм.

Алтан амь: “МНТ”-ы §233. “... Kebteül lu minu altan amin sakimuy.” (МНТ. 1985:170) Монгол хэлний үгийн сангийн “алтан” хэмээх нэгж/үглэвэр/ бол эртний

түүхэн метафор үүсгэх утга шилждэг өвөрмөц нэгж болох нь илэрхий байна. “Алтан” хэмээх үглэвэр сонгосон метафорыг С. Мөнхсайхан: “Алтан амь гэдэг нь хааны амь нас хийгээд эрүүл мэндийг, зөвхөн эзэн Чингис хааныг хүндэтгэн заах утгатай аж. ... Түүний амьдран суух өргөө гэрийг “алтан босго”, Чингис хааны байлдан дагуулал, аян дайныг “алтан жолоо”, бусад улс үндэстэнтэй байгуулсан улс төрийн найрсаг харилцааг “алтан аргамж” гэх мэтээр хүндэтгэн нэрлэсэн байдаг.” (2023:57) хэмээн тайлбарласан явдал бол бидний мөшгөж буй метафорыг онож хэлсэн ажээ. “... Өвөрмөц хэллэг (idiom) бол энэхүү метафорын нэг зүйл юм.” (Баянсан, Ж. 2016:23) гэсэнчлэн алтан гэх тодотголтой өвөрмөц хэлц бүр хэлний түүхэн метафорын утгатай ажээ. Тухайлбал:



Бүдүүвч № 2. Хэлний метафор.

Эдгээр түүхэн метафор бол О. Шинэбаяр нарын “Чимэг зүйрлэл (адилтгал): Зүйрлэхүүн нь зүйрлэгдэхүүнийхээ аль нэгэн шинж байдлыг онцлон товойлгосон тодотгол болдог зүйрлэлийг чимэг зүйрлэл гэж нэрлэнэ.” (2020:67) гэсэнчлэн чимэг зүйрлэл болно.

Басхүү “нохой” хэмээх үгийн цөм утгыг шилжүүлэн түүхэн метафор бүтээж байжээ. Үүнд:

Нохос: “Монголын Нууц Товчоон”-ы §195. “Tede dörben noqays širemün manglaytan, šiüči qošiutan, šibüge keleten, temür öreten, üldü minaatан, siüder-i idejü, key unaju, yabud tede.” §209. “...Ede Qubilay, Jelme, Jebe, Sübeetey ta dörben nohas-iyan sedkigsen-dür joriulju ileesü ...” (МНТ, 1985:154) гэж хэлж байгаагаас үзэхэд, Хувилай, Зэлмэ, Зэв, Сүвээдэй дөрвийг нохой мэт үнэнч хэмээж, хүнийг нохойтой зүйрлэсэн байна. Мөн “ширмэн магнайтан, цүүцэн хошуутан, шөвөг/шивээ/ хэлтэн, төмөр өртөн, илд ташууртан, шүүдэр идэж, хий унаж явна...” (МНТ, 2000:118-119) гэж дөрвөн нохсыг дүрсэлсэн нь хэтрүүлэл утгатай хэлний түүхэн метафор юм.

Чингис хааны цэргүүд аян дайнд явахдаа зүйл зүйлийн арга хэрэглэж байжээ. Тэрхүү аргуудын нэрнээ түүхэн метафор бий. Жишээ нь: Нохой хэрэл: “МНТ”-ы §194. “Altay-yin ölkес kürtele noqay kerel kerejü yabuqu bidan-u aytas tarqud buy.” (МНТ. 1985:130) гэж нохой мэт явдлаар явах утгатай. Мөн эмэгтэй хүний зүс царай үзэмжгүйг илтгэсэн утгатай метафор ч хэрэглэж байжээ. Жишээ нь: Нохой нүүрт: “МНТ”-ы §188. “Eme küün noqay niurtaу keegdeyi je bi.” (МНТ. 1985:123) гэх мэт. “МНТ”-ы зарим метафор бол өвөрмөц хэлцийн дайтай бүтэцтэй ч байна.

Үүнд:

Монголчуудыг Эсгий туургатан гэхчлэн юмны хэсгээр, бас -тан /-тэн,-тон,-төн/ гэсэн дагавраар бүхэл бүтэн үндэстнийг нэрлэсэн түүхэн метафор үүсгэсэн байдаг. Тухайлбал:

-Эсгий туургатан, Хавтсан үүдтэн: “МНТ”-ы §203. “... isgey tuuryatan-i iriṣeüljü, qabtasun eüdeten-i qaγaṣaulju qubilaju ög.” (МНТ. 1985:149)

-Морин унаатан, Модон нөмөртөн: “МНТ”-ы §174. “... Morin unuatan, modun nemüretün bolba tede.” (МНТ. 1985:106)

-Тэрэм гэрт/эн/, Тэмээн ачаат/ан/: “МНТ”-ы §265. “... terme ger-tü temeen aṣiatu irgen ...” (МНТ. 1985:199) хэмээх юмын хэсэг зүйлээр бүхлийг төлөөлөн нэрлэсэн нь үндэстнийг танин мэдсэн утга бүхий [үндэстэн (зүйрлэгдэхүүн), Эсгий туургатан, хавтсан үүдтэн; Морин унаатан, модон нөмөртөн; Тэрэм гэртэн, тэмээн ачаатан (зүйлэхүүн)] гэсэн түүхэн метафор ажээ.

ХОЁР. Уран зохиолын түүхэн метафорын утга

Уран зохиолын метафор гэдэг бол ямарваа эхийн доторх дэлгэрэнгүй бүтэц, бүрэлдүүлбэр бүхий, зүйрлэх арга нь хэлний зүйрлэлтэй адил авч, цаашид юмны нэр болж тогтворжиж чадахгүй, ихэвчлэн олон зүйрлэхүүнт дүрслэх ур маяг юм.

“Монголын Нууц Товчоон”-д хүнийг амьтантай жишин харьцуулсан түүхэн метафор хэд хэд байна. Арван хоёр араатан, амьтан, шувуу, загас зэргийн зэрлиг араншинг танин мэдсэн учраас, Тэмүжин Хасар хоёрын хүний амь бүрэлгэснийг түүнтэй жишин харьцуулж буй нь монгол хүний сэтгэн бодсон сөрөг утгатай метафорын онцлог юм. Энэхүү уран зохиолын зүйрлэл нь зүйрлэж буй амьтны нэрийн хойно “мэт” гэх илтгэгч үгийг дагуулж, олон зүйрлэхүүнт сэтгэл хөдлөлт метафорын сөрөг утгыг үзүүлжээ. Тухайлбал: “МНТ”-ы §78 -д:

“... Qarbisu-ban qajaqu qasar noqay metü, Хабисаа (хальс навчаа) хазах хасар нохой мэт,

Qada-dur dobtulqu qablan metü, Хаданд довтлох хавлан бар мэт,

Aur-ıyan darun yadaqu arslan metü, Агураа даран ядах арслан мэт,

Amida jalgisu kekü mangyus metü, Амьдаар залгис хийх мангас мэт,

Seüder-tür-ıyen dobtulqu singqor metü, Сүүдрээ довтлох шонхор мэт,

Sem-ıyer jalgıqu čuraqa metü, Сэмээр залгих цурхай мэт,

Botoyan-ıyan borbi qajaqu buura metü, Ботгоныхоо борвийг хазах буур мэт,

Boroyan-dur siqaqu čino metü, Бороонд шахах чоно мэт,

Köüd-ıyen gelin yaduqu köüd-ıyen idekü anggir metü, Хөвүүдээ хөөн ядаж, хөвүүдээ идэх ангир мэт,

Kebtesi-ben köndeesü ömerkü cöeböri metü, Хэвтэшээ хөндөвөөс өмөөрөх цөөвөр мэт,

Barıju ülü saaraqı bars metü, Барьж үл саарах барс мэт,

Balamud dobtulqu baruq metü. Балмад довтлох баруг /нохой/ мэт. ...” (МНТ, 1985:30) гэжээ. Эл жишээнээс үзвэл, Тэмүүжин Хасар хоёрыг “нохой мэт, хавлан

мэт, арслан мэт, мангас мэт, шонхор мэт, цурхай мэт, буур мэт, чоно мэт, ангир мэт, цөөвөр мэт, барс мэт, бараг мэт” хэмээн 780 гаруй жилийн тэртээ түүхэн метафор хэрэглэж байсан ажээ. Энэ тухай Д. Отгонтуяа (2008:106-110) нэлээд дэлгэрэнгүй тайлбарлаж, орчуулгыг ажигласан байна. Эрт цагаас янагш араатан амьтны араншныг танин мэдээд, гинжин метафор бүтээж дүрсэлсэн нь монголын утга зохиолд түгээмэл байдаг. Жишээлэхэд, “Оюун түлхүүр” сургаалд: Арслан мэт ноёдыг барс мэт түшмэд дагах, барс мэт ноёдыг ирвис мэт түшмэд дагах, ирвис мэт ноёдыг чоно мэт түшмэд дагах, чоно мэт ноёдыг үнэг мэт түшмэд дагах тул хамагт зовлон болно.” (Зуун билиг, 1959:52) гэх мэт.

Болж- хэмээх үйл үгээр утгыг шилжүүлэн илэрхийлж, амьтан, шувуу, юм болж хувирсан явдал метафор үүсгэдэг ажээ. Жишээ нь: “Монголын Нууц Товчоон”-ы §125. “Tende Činggis qayan qan bolju, Boorču Jelme qoyar-a ügülerün: Ta qoyar namayi seüder-eče busu nöbür ügey-dür seüder bolju, ... seül-eče busu čičua ügey-dür seül bolju ...” (МНТ. 1985:61), §199. “Toytoa-yin Qudu, Gal, Čilaun teriüten... uyuryatu qulan, sumutu buyu bolju odba. Teden-i jüürtü bolju, niscčü tenggeri-dür yaruasü čü Sübeetey šingqor bolju, niscčü ülüü bariujiyi. Tarbaýan bolju kimü-suar-ıyan maltaju ýajar-tur oroasu čalir bolju čokiju erijü ülüü güyicëkü čü. Jıyasun bolju tenggis dalai-dur oroasu čü Sübeetey gölmi ýubčıur bolju šiüjü ýubčıu ülüü abqu čü.” (МНТ. 1985:141), §210. “... qara söni gendü bolju, gegeen üdür qara kerie bolju.” (МНТ. 1985:141-142) §203. Нүд, чих бол-: “Möngke tenggeri-de iheegdejü gür ulus-i jügüeljü büküy-dür čü üjekü-yin nidün, sonosqu-yin čikin bolju ...” (МНТ. 1985:149) Эл хэсэгт “бол-” гэх үйл үгийн өмнөх үг, хэллэг бол зүйрлэсэн утга учиртай болсон тул “бол-” гэх үйл үг илтгэгчтэй түүхэн метафор гэж үзсэн юм.

“Монголын Нууц Товчоон”-ы үгийн санд судлаачдын нүд хужирлаж, ухаанаа уралдуулж ханддаг цөөн хэдэн хэвшмэл хэлцийн дотор үглэврийн утга шилжүүлэн найруулсан, түүхэн метафор байгааг хэд хэдэн жишээгээр тайлбарлая. Үүнд:

“Монголын Нууц Товчоон”-ы §181. “Basa Činggis qayan Senggüm anda-da ügüle keen ügülerün. Deeltü töregsen köün bi ajuu je. Ničügün töregsen köün čü ajuu.” (МНТ. 1985:115) гэж өгүүлснээс ургуулан бодвол, нүцгэн төрсөн гэдэг нь өмнө мэндэлсэн, дээлтэй төрсөн гэдэг нь сүүлд мэндэлсэн гэх утгатай учраас [өмнө (зүйрлэгдэхүүн) - нүцгэн (зүйрлэхүүн), сүүлд (зүйрлэгдэхүүн) - дээлтэй (зүйрлэхүүн)] гэх түүхэн метафор юм. Метафорын утгыг ухвал, түрүүнд хүү болсон нь нүцгэн төрөх, сүүлд хүү болсон нь дээлтэй төрөх гэж зүйрлэх нь зохистой ажээ. Д. Цэрэнсодном: “Чингис хаан Ван ханы хүү Сэнгүмтэй анд бололцож, ах дүү барилдсан тул үнэндээ Ван ханд Чингис бол сүүлд заяасан хүү буюу НТ-нд өгүүлснээр “дээлтэй төрсөн хүү” болно.” (МНТ, 2000:291) гэж утгалжээ.

§72. “... Čeel usun niduralua, Čegen čilaun čauralua keej neüjeey.” (МНТ.1985:27) С. Мөнхсайхан “... Юуны өмнө “цээлийн ус нударлаа” гэсэн өгүүлбэрийг үгсийн утгад нь тулгуурлан “тол усны хөл алдам хэсгийн ус татарсан” гэсэн санаатай

хэмээн ойлгож болно. Удаах өгүүлбэрт уг санаагаа давтан хэлсэн буюу “хээрийн цул чулуу хагарсан” гэжээ. Өөрөөр хэлбэл, гол усны татрах боломжгүй хэсгийн ус, байгалийн цул чулуу хоёр татарч, хагарч байгааг угаас нэг овог аймгийн угсаа гарвал нэгтэй, амь нэгтэй байх ёстой хүмүүс нэгнээ хаяж буйтай далд зүйрлэн “Энэ мөчөөс эхлэн бидний зам саллаа” хэмээн хэлжээ.” (2023:104) гэж метафор болохыг нотолж бичсэн байна.

Есүхэй баатар нас барж, овог аймгийн хүмүүс Өэлүн эхийг үр хүүхдүүдтэй нь нутаг нугад нь орхин нүүж буй ийм нөхцөл байдалд хэлсэн “МНТ”-ы §76. “Seüder-ece busu nökög ügey, Seül-ece busu čičua ügey buy.” (МНТ. 1985:29) гэсэн хэвшмэл хэлцийн дотор [Сүүдэр (зүйрлэхүүн) - нөхөр (зүйрлэгдэхүүн), Сүүл (зүйрлэхүүн) - ташуур (зүйрлэгдэхүүн)] гэсэн түүхэн метафор хэрэглэсэн ажээ.

§77. “... namayı yakin nidün-ü surmusun aman-u qayasun bolıamuy ta.” (МНТ. 1985:30) Энд “сормуус мэт, хахаас мэт” гэсэн утгаар л [намайг (зүйрлэгдэхүүн), сормуус, хахаас (зүйрлэхүүн)] гэсэн түүхэн метафор болно.

Монголын утга зохиолд хүүхэд залуучуудыг нүдэнд дулаахан гэж дүрслэхдээ: “МНТ”-ы §62. “... Dey seçen ügülerün. Ene köün činu nidün-dür-iyen yaltu, niur-tur-ıyan gereltü köün buy.” (МНТ, 1985:24) гэдэг. Тэгэхдээ [цовоо (зүйрлэгдэхүүн) - галт, гэрэлт (зүйрлэхүүн)] гэсэн түүхэн метафор ажээ.

Хожуу үеийн зарим судлаачдын ажиглалт судалгаанд [“Монголын нууц товчоон”-д мөн “наран мэт гэгээн, нуур мэт дэлгэр” (§254) “үүл арилж эх наран харсан мэт, мөс арилж ус мөрөн гарсан мэт” (§238) “эчнээ боловч ил мэт, хол боловч ойр мэт” (§199) “хавиргаа хазах хасар нохой мэт, хаданд довтлох хавлан мэт” (§78) “одтой тэнгэр орчиж бүлгээ, олон улс булха /дайсагнах/ бүлгээ”, “хөрстэй этүгэн хөрвөж бүлгээ, гүр улс булха бүлгээ” (§254) “хар нүдээ ирмэс үл хийн, хавтгай чихээ дэрэнд үл талбин, ханцуйгаа дэрлэн, хормойгоо дэвсэж, шүлсээрээ ундаалж, шигигээ хоноглож /шүдний завсар дахь махаар хооллох/” (§254) “хүнд эмийн шээхүй газар эс гарсан, хүрдний тугалын бэлчээрт эс хүрсэн” (§194) “хар хэрээ харамбай нугас барих болов, харц боол хаан эзэндээ халдах болов” (§200) гэх мэтээр адилтгал, зүйрлэлийн аргаар бүтсэн уран сайхны дүрслэл олонтоо тааралдана.”] (МНТ, 2023:19-20) хэмээн дурдсан явдал бол уран зохиолын түүхэн метафор нэлээд байна гэсэн үг юм. “Монголын Нууц Товчоон”-ы хэлнээ түүхэн метафор дэлгэр байгаа нь XIII зуунд монгол хэлний найруулга ихээхэн боловсорч байсныг л гэрчилж байна.

Судалгааны үр дүн: “Монголын Нууц Товчоон”-ы хэлний чухал баримтыг орчин үеийн хэл шинжлэлийн онол, мэдлэгийн үүднээс авч үзэхэд, хэл шинжээчдийн судалгааны сонирхол илүүтэй татах метафор нь эртний болон дундад үеийн монгол хэлтний сэтгэхүй, сэтгэлгээний өвөрмөц талыг илэрхийлж байгааг, бидний дээрх ажиглалтаас харж болох юм. Тэрхүү түүхэн метафорыг бид 1. Хэлний метафор, 2. Уран зохиолын метафор гэж хоёр ангилж тус бүрд нь эрдэм шинжилгээний тайлбар хийсэн явдал судалгааны гол үр дүн боллоо.

Дүгнэлт

“Монголын Нууц Товчоон”-ы түүхэн метафорыг нарийвчлан судалснаар XIII зуун буюу дундад үеийн монгол хэлний түүхэн метафорыг танин мэдэж, улмаар монгол хэлний түүхэн утга судлалын судалгаанд ач холбогдолтой болох юм. “МНТ”-ы хэлнээ хэлний болон уран зохиолын метафор цөөнгүй байгаа нь XIII зууны монгол бичгийн хэлний үгийн сан, хэлзүйн найруулга төгөлдөржсөн байдал, монгол хүний сэтгэхүй, сэтгэлгээний онцлог илэрч байна. Энэ нь “Монголын Нууц Товчоон” бол хэлний дурсгал болохыг ч баталж байна. Хэрэглээ зүйн үүднээс дүгнэвэл, үгийн олон утгыг үүсгэх нэгэн хүчин зүйл болсон, утгыг утгатай зүйрлэн жишдэг метафор бол эртний үүсэлтэй, урт хугацаа, уудам орон зайд тархмал утгазүйн уламжлалын хувьсал, хөгжлийг харуулсан Далай хаан, Чингис хаан, алтан аргамж, алтан босго, алтан амь, нохой мэт, хавлан мэт, эм Таян, дөрвөн нохос ... гэх мэтээр хэрэглээтэй байсаар, монгол сэтгэхүй, танин мэдэхүй, хэлний өвөрмөц онцлог, утга учрыг хадгалсаар ч байх ажээ.

Abstract:

The author observed metaphors of the Secret History of the Mongols in detail in his academic article, and explained how Mongolians abstractly thought and developed metaphorical way of thinking more than 780 years ago. In particular, he pointed out that there many metaphors used to describe some characteristics of Mongolian people, by recognizing the behavior of animals, fish, and birds. For example, in the Section 78 of the Secret History of the Mongols, When Temüjin and Khasar came to the house, ... Öelün Üjin reprimanded using harsh, and old wordings such as “... Noqay metü, qablan metü, arslan metü, mangyus metü, singqor metü, čuraqa metü, buura metü, čino metü, anggir metü, čöeböri metü, bars metü, baruq metü.” (Secret History of the Mongols, 1985:30).

Also, the author explained the lexemes with transferred meanings such as God, golden, dog, etc., as well as metaphorical words as like/as, so much/that much, and turn to after comparing mythological and pagan idol names of the Secret History of the Mongols with human and animal names. He concluded that some proper names and collocations such as Börte Čino, Goo Maral, Chinggis, a reddish cow, a red bull, a pale yellow man, like an yellow dog, Teb Tenggeri have historical metaphor meanings. It can be considered that metaphors of the Secret History of the Mongols may be divided into two categories such as 1. Language metaphor and 2. Literary metaphor.

Ном зүй

Монгол хэлээр

- Бадамдорж, Д.** (2019). *Монгол хэлний зүйрлэлийн унаган дархлаа, жишиг хэмжүүр*. МУИС. Монгол судлал. ЭШБ. XLIII. (520) 19-26. [Badamdorj, D. *Mongol helnii zuirleliin unagan darhlaa, jishig hemjүүr*. [The inherent immunity of Mongolian language metaphors, a benchmark]. NUM. Mongolian Studies. XLIII. (520) 19-26. 2019]
- Баянсан, Ж.** (2016). *Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ*. Улаанбаатар: 23, [Bayansan, J. *Soyol, hel, үндэстний setgelgee*. [Culture, language, national mentality]. Ulaanbaatar: 23, 2016]
- Баянсан, Ж.** (2023). Тархи сэтгэхүйн үйл ажиллагаа, метафорын утгын хамаарал. Буддын ухаан ба шинжлэх ухаан дахь танин мэдэхүй. ЭШ-ний бага хурал. Илтгэлүүдийн эмхэтгэл. Улаанбаатар: 256-269, [Bayansan, J. *Tarhi setgehүүi үйл ajillagaa, metaforiin utgiin hamaaral*. [The relationship between Mental activity and metaphor meaning. Cognition in Buddhist thought and science. Conference]. Collection of papers. Ulaanbaatar: 256-269, 2023]
- Буянбат, Г.** (1985). *Монголын бөө мөргөлийн шашны учир*. Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо. Хайлаар хот. 126, [Buyanbat, G. *Mongoliin бөө mörgөliin shashnii uchir* [The reason for Mongolian shamanism]. Inner Mongolian Cultural Publishing House. Khailaar city. 126, 1985]
- Бүрэнбат, (2002).** *Монголын нууц товчоон дахь нэгэн зүйрлэл үгийн тухай*. Монгол хэл бичиг сэтгүүл. № 7. Хөх хот. 3-7, [Burenbat. *Mongoliin nuuts товchoon dahi negen зүүrlel үгийн tuhai*. [On a metaphor in the “The Secret History of the Mongols”]. “Mongolian Language and Literature” Journal. No. 7. Khokh Khot. 3-7, 2002]
- Гаадамба, Ш.** (1989). *Утга зохиолын онолын үндэс*. Улаанбаатар: 125-126, [Gaadamba, Sh. *Utga zohioliin onoliin үндес*. [The foundations of literary theory]. Ulaanbaatar: 125-126, 1989]
- Дамдинсүрэн, Ц.** (1957). *Монголын уран зохиолын тойм*. Нэгдүгээр дэвтэр. XIII-XVI зууны үе. Улаанбаатар: 72, [Gaadamba, Sh. *Mongoliin uran zohioliin тойм*. [The foundations of literary theory]. Ulaanbaatar: 125-126, 1957]
- Зуун билиг, (1959).** *Монголын уран зохиолын дээж зуун билиг оршив*. Эмхэтгэсэн Ц. Дамдинсүрэн. Улаанбаатар: 52, [Zuun bilig. *Mongoliin uran zohioliin deej zuun bilig orshiv*. [A sample of Mongolian literature named “Zuun bilig”]. Compiled by Ts. Damdinsuren. Ulaanbaatar: 52, 1959]
- Лувсандорж, Ж.** (2007). *Монголын нууц товчоог метафорын толинд харах нь*. “Mongolica” Volume 20(41). Улаанбаатар: 74-99, [Luvsandorj, J. *Mongoliin nuuts товchoog metaforiin tolind harah нь*. [Study on the Secret History of the Mongols from a point view of Metaphorical] “Mongolica” Volume 20(41).

- Ulaanbaatar: 74-99, 2007]
- Лувсандорж, Ж.** (2008). “Монголын нууц товчоо” ба метафор. МУИС-ийн Монгол судлалын төвийн “Acta Mongolica” ЭШБ. VIII (306) боть. Улаанбаатар: 31-56, 52, [Luvsandorj, J. “Mongoliin nuuts товчоо” ба metaphor. [“The Secret History of Mongols” and Metaphor]. “Acta Mongolica” of the Mongolian Studies Center of the National University of Mongolia. Volume VIII (306). Ulaanbaatar: 31-56, 52, 2008]
- Лувсанжав Чой,** (2006). Монгол хэлний өвөрмөц хэллэг. Эрдмийн хэлхээ IV. Улаанбаатар: 24, [Luvsanjav Choi. *Mongol helnii övörmöts helleg*. [Mongolian language idioms]. Academic series IV. Ulaanbaatar: 24, 2006]
- Лхагва О,** (2021). Цэгээн шар хүн хэн бэ? Тэнгэр тавилан хурайлагтун. Улаанбаатар: 147, 158, [Lkhagva O. *Tsegeen shar хүн hen be? Tenger tavilan khurailagtun*. [Who is the light- yellow man?] Tenger tavilan khurailagtun. Ulaanbaatar: 147, 158, 2021]
- МНТ,** (1985). Монголын Нууц Товчоо. Галиглаж хэвлүүлсэн Т. Дашцэдэн. Улаанбаатар: 10, 12, 14, 24, 27, 29, 30, 43, 57, 59, 61, 67, 70, 81, 96, 104, 106, 114, 115, 119, 123, 126, 130, 141, 141-142, 149, 151, 154, 170, 174, 176, 192-193, 195, 199, 206, 214, [MNT, *Mongoliin nuuts товчоо*. [The Secret History of Mongols]. Translated and published by T. Dashtsedeen. Ulaanbaatar: 10, 12, 14, 24, 27, 29, 30, 43, 57, 59, 61, 67, 70, 81, 96, 104, 106, 114, 115, 119, 123, 126, 130, 141, 141-142, 149, 151, 154, 170, 174, 176, 192-193, 195, 199, 206, 214, 1985]
- МНТ,** (1990). Монголын Нууц Товчоо. Худам (язгуур эртний) монгол бичгээр монгол бичиг, утга судлалын үүднээс III. Гаадамбын төсөөлөн нягталж, сэргээсэн сийрүүлэг эх, тайлбар. Улаанбаатар: 222, 229, [MNT, *Mongoliin nuuts товчоо*. [The Secret History of Mongols]. Khudam (original ancient) Mongolian script, with the help of Sh. Gaadamb’s imaginatively revised and restored inscriptions and explanations. Ulaanbaatar: 222, 229, 1990]
- Цэрэнсодном Д,** (2000). Монголын Нууц Товчооны орчуулга, тайлбар. Улаанбаатар: 09, 118-119, 191, 298, Tserensodnom, D. *Mongoliin nuuts товчооний орчуулга, тайлбар*. [Translation and commentary of the The Secret History of Mongols]. D. Tserensodnom. Ulaanbaatar: 09, 118-119, 191, 298, 2000]
- МНТ,** (2023). Дэлгэрэнгүй тайлбартай монголын нууц товчоон. Хамтын бүтээл Улаанбаатар: Улаанбаатар. 19-20, [MNT. *Delgerengüi тайлбартай Mongoliin nuuts товчоон*. [The Secret History of Mongols with detailed commentary]. Collaborative work Ulaanbaatar: Ub. 19-20, 2023]
- Мөнхсайхан, С.** (2023). “Монголын нууц товчоон”-ы утга зүй, соёл, сэтгэлгээ. Улаанбаатар: 111, [Mönkhsaikhán, S. *Mongoliin nuuts товчооний утга зүй соёл setgelgee*. [The meaning, culture, and mentality of “The Secret History of the Mongols”]. Ulaanbaatar: 111, 2023]
- МУЗНТ,** (2022). Монголын Утга Зохиолын Нэвтэрхий толь. -1. (А-З). Анхдугаар

- хэвлэл. Улаанбаатар: 463, [MUZNT. *Mongoliin utga zohioliin nevterhii toli*. [Mongolian Literary Dictionary]. -1. (A-Z). First edition. Ulaanbaatar: 463, 2022]
- Мэнд Н**, (2005). “Монголын нууц товчоон”-ы зүйрлэлийг монгол, солонгос хэлээр зэрэгцүүлсэн ажиглалт. МУИС-ийн ГХСС-ийн “Солонгос судлал” ЭШБ. №1. Улаанбаатар: 36-60, [Mend N. *Mongoliin nuuts товchoonii зүйрleliig mongol, solongos heleer zereгtsүүlsen аjiгlalt*. [A parallel observation of the metaphors of “The Secret History of the Mongols” in Mongolian and Korean. “Korean Studies” the academic serial of the School of Foreign Languages , NUM. №1. Ulaanbaatar: 36-60, 2005]
- Нямжав, Б.** (2008). “Монголын нууц товчоон” дахь зүйрлэлийн англи орчуулгын харьцуулал /Магистрын зэрэг горилсон зохиол/. Улаанбаатар: 137, Nyamjav, B. *Mongoliin nuuts товchoon dahi зүйрleliin англи mongol орchuulgiin haritsuulal*. [Comparison of English translations of metaphors in “The Secret History of the Mongols”] /Master’s thesis/. Ulaanbaatar: 137, 2008]
- Отгонтуяа, Д.** (2008). “Монголын нууц товчоон”-д хүнийг амьтантай зүйрлэснийг англи хэлнээ орчуулсан нь. МУИС-ийн ГХСС-ийн “Гадаад хэл, соёл судлал” ЭШБ. XII (295) боть. Улаанбаатар: 106-110, Otgontuya, D. *Mongoliin nuuts товchoond хүniig amitantai зүйrlesniig англи helnee орchuulsn ni*. [The English translation of the metaphors of humans with animals in “The Secret History of the Mongols” “Foreign Languages and Cultures”, academic serial of the School of Foreign Languages , NUM. XII (295) vol. Ulaanbaatar: 106-110, 2008]
- Пүрэвжав, Э.** (2023). Монголын нууц товчоон судлалын ном зүй. Улаанбаатар: 11, [Purevjav, E. *Mongoliin nuuts товchoon судlaliin ном зүй*. [Bibliography of Studies on “The Secret History of the Mongols”. Ulaanbaatar: 11, 2023]
- Сумьяабаатар, Б нар.** (2008). Б.Сумьяабаатар, Б. Нарангэрэл. Монголын нууц товчооны толь. Улаанбаатар: XIX, [Sumyaabaatar, B et al. B. Sumyaabaatar, B. Narangerel. *Mongoliin nuuts товchoonii toli*. [Dictionary of The Secret History of the Mongols]. Ulaanbaatar: XIX, 2008]
- Сүхбаатар, Ц нар.** (1967). Ц. Сүхбаатар, Г. Бадан *Найруулга зүйн товч толь*. Улаанбаатар: 21, 34, [Sukhbaatar, Ts. Ts. Sukhbaatar, G. Badan, *Nairuulga зүйin товch toli*. [A brief dictionary of stylistics]. Ulaanbaatar: 21, 34, 1967]
- Түмэндэмбэрэл, Ц.** (2006). Монголын нууц товчооны хэлц хэллэг. Улаанбаатар: 86, [Tumendemberel, Ts. *Mongoliin nuuts товchoonii helts helleg*. [Phrases of the “The Secret History of the Mongols”]. Ulaanbaatar: 86, 2006]
- Хай сия**, (2013). “Монголын нууц товчоон”-ы зүйрлэл үгийн тухай. Дундад улсын монгол судлал сэтгүүл. № 2. Хөх хот. 140-145, [Khai siya. *Mongoliin nuuts товchoonii зүйrlel үgiin tuhai*. [The metaphors in “The Secret History of the Mongols”]. Journal of Mongolian Studies, PRC. No. 2. Khokh khot. 140-145, 2013]
- Цэвэлсүрэн Г**, (2006). “Монголын нууц товчоо”-ны зүйрлэл, адилтгалыг франц

хэлнээ орчуулсан онцлог. /Хэлбичгийн ухааны доктор (Ph.D) зэрэг горилсон диссетацн/. Улаанбаатар: 145, [Tsevelsuren G. *Mongoliin nuuts tovchoonii züirlel, адилтгалиг франс хелне орчуулсан онцлог*. [Translation features of the metaphors in “The Secret History of the Mongols” into French] /dissertation for the degree of Doctor of Philology (Ph.D.)/. Ulaanbaatar: 145, 2006]

Цэрэнсодном, Д. (2008). *Монголын нууц товчооны утга зүй, уран сайхны шинжилгээ*. Уб. 60, 77, [Tserensodnom, D. *Mongoliin nuuts tovchoonii utga züi, uran сайхны шинжилгээ*. [The meaning and artistic analysis of The Secret History of the Mongols’]. Vol. 60, 77, 2008]

Чүлтэмсүрэн, Р. (2021). *Монгол аман зохиолын түүх*. 1. Улаанбаатар: 240, [Chultemsuren, R. *Mongoliin аман зohiolin түүх*. [History of Mongolian folklore]. 1. Ulaanbaatar: 240, 2021]

Шинэбаяр, О. (2022). Метафор судлалын уламжлал, хөгжлийн асуудалд. Монгол нэр томъёо судлал. Улаанбаатар: 55, [Shinebayar, O. *Metafor судлалын уламжлал хөгжлийн асуудалд*. [Issue on the tradition and development of Metaphor studies]. Mongolian terminology. Ulaanbaatar: 55, 2022]

Шинэбаяр, О нар. (2020). О. Шинэбаяр, Б. Золжаргал. *Адилтгалын аргаар бүтсэн монгол нэр томъёо*. Улаанбаатар: 67, [Shinebayar, O. et al. О. Shinebayar, B. Zoljargal. *Adiltgaliin argaar бүтсэн mongol ner tomiyo*. [Mongolian terminology created by the metaphor]. Ulaanbaatar: 67. 2020]

Гадаад хэлээр

Alena, 2006. Alena Oberfalzerova. Metaphors and Nomads. Charles University Philosophical Faculty Institute of South and Central Asian Studies.

Geoffrey Leech, 1974. Semantics. A Pelican Original. England. 146, 213, 216, 231,

John Lyons, 1995. Linguistic semantics. An introduction. Cambridge university press. 13,

Urgunge Onon, 2001. The secret history of the Mongols. London and New York. 38,

Lakoff, G. 2006. The Contemporary Theory of Metaphor. In Cognitive Linguistics. Basic Reading. Mouton de Gruyter. Pp. 232



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.